



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2018 оны 4 дүгээр сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 23%-иар буюу 690 сая ам.доллараар өсч 3,707 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 12%-иар буюу 226 сая ам.доллараар, импорт 42%-иар буюу 464 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 238 сая ам.доллараар буурч 543 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 4 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	2,210	3,017	3,707	807	37%	690	23%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	1,347	1,900	2,125	552	4%	226	12%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	863	1,118	1,582	255	30%	464	42%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	485	782	543	297	61%	(238)	-31%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2018 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 194 сая ам.доллараар буурч 610 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 65% буюу 2,405 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 503 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 50%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 15%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 11%-иар, өмнөх сараас 9%-иар өсч 1.911-д хүрлээ. Тайлант сард нүүрсний экспортын өсөлт голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирчээ.

Экспорт 2018 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 12%-иар буюу 226 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 12.5 нэгж хувиар өсөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 1.6 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 1.3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	%²	Дүн	Өсөлт	%²
1. Уул уурхай		1,179	88%	1,707	90%	1,944	91%	528	45%	39%	237	14%	12.5%		
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	558	637	47%	502	524	28%	459	628	30%	(114)	-18%	-8%	104	20%	5%
1.2. Чулуун нүүрс	5,008	155	12%	11,432	766	40%	10,142	790	37%	611	394%	45%	23	3%	1%
1.3. Боловсруулаагүй нефть	2,876	99	7%	2,430	123	6%	2,210	139	7%	24	24%	2%	16	13%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	1,380	45	3%	1,742	114	6%	2,036	93	4%	69	155%	5%	(21)	-19%	-1%
1.5. Мөнгөжөөгүй алт /kg/	4,304	168	12%	1,889	76	4%	3,432	144	7%	(92)	-55%	-7%	69	91%	4%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	38	39	3%	38	57	3%	42	75	4%	18	45%	1%	18	31%	1%
1.7. Жонош, лейцит, нефелинт	74	17	1%	79	18	1%	114	36	2%	2	9%	0%	18	98%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	8	1%	2	11	1%	2	14	1%	3	41%	0%	3	31%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	2	0%	0	1	0%	0	1	0%	(1)	-58%	0%	0	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	20	8	1%	0	0	0%	0	0	0%	(7)	-96%	-1%	(0)	0%	0%
1.11. Бусад	39	1	0%	152	17	1%	187	23	1%	16	20%	1%	6	36%	0%
2. Мал аж, ахуй	87	74	5%	154	91	5%	161	97	5%	17	23%	1%	6	7%	0.3%
2.1. Амьд мал, малын мах	2	4	0%	3	6	0%	7	16	1%	2	53%	0%	10	165%	1%
2.2. Арьс, шир	79	14	1%	145	13	1%	147	8	0%	(2)	-11%	0%	(4)	-35%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	2	0%	0	1	0%	0	3	0%	(1)	-29%	0%	1	0%	0%
2.4. Ноолуур	2	48	4%	2	66	3%	4	66	3%	18	38%	1%	(0)	0%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	4	6	0%	3	4	0%	2	4	0%	(1)	-26%	0%	(1)	-14%	0%
2.6. Бусад	0	0	0%	1	1	0%	0	1	0%	0	288%	0%	(0)	-4%	0%
3. Газар тариалан	78	10	1%	35	3	0%	2	1	0%	(7)	-71%	-1%	(2)	-66%	-0.1%
4. Аж үйлдвэрлэл	89	85	6%	160	99	5%	81	83	4%	14	16%	1%	(15)	-15%	-0.8%
4.1. Хүнс	2	12	1%	9	38	2%	8	25	1%	26	217%	2%	(13)	-35%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	2	0%	0	4	0%	0	5	0%	2	75%	0%	1	29%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	4	0%	0	3	0%	1	4	0%	(0)	-11%	0%	0	12%	0%
4.4. Уул уурхай	8	22	2%	11	39	2%	13	36	2%	17	79%	1%	(3)	-8%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-77%	0%	0	251%	0%
4.6. Машины механик, тоног төхөөрөмж, эд анги	0	43	3%	1	12	1%	1	11	1%	(31)	-72%	-2%	(1)	-6%	0%
4.7. Бусад	79	1	0%	139	2	0%	58	2	0%	0	26%	0%	0	1%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-25%	0%	0	8%	0.0%
Нийт дүн		1,347		1,900		2,125		552	41%	226	12%				

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 4 дүгээр сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(76)		312		237	14%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(59)	-57%	163	157%	104	20%
1.2. Чулуун нүүрс	(10)	-428%	124	528%	23	3%
1.3. Боловсруулаагүй нефть	(14)	-86%	30	186%	16	13%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	13	-63%	(35)	163%	(21)	-19%
1.5. Мөнгөжөөгүй алт /kg/	65	94%	4	6%	69	91%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	6	33%	12	67%	18	31%
1.7. Жонош, лейцит, нефелинт	11	61%	7	39%	18	98%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(2)	-52%	5	152%	3	31%
1.11. Бусад	4	71%	2	29%	6	36%
2. Мал аж, ахуй	30		(23)		6	7%
2.1. Амьд мал, малын мах	8	84%	2	16%	10	165%
2.2. Арьс, шир	0	-3%	(5)	103%	(4)	-35%
2.3. Малын өлөн гэдэс	1	113%	(0)	-13%	1	0%
2.4. Ноолуур	21		(21)		(0)	0%
3. Газар тариалан	(18)		16		(2)	-66%
4. Аж үйлдвэрлэл	9		(24)		(15)	-15%
5. Бусад	(0)		0		0	8%
Нийт дүн	(55)		281		226	12%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

2018 оны эхний 4 сард экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 55 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 281 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ буурснаас шалтгаалж 160 сая ам.доллараар буурсан хэдий ч үнэ өссөнөөс шалтгаалж 287 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 9 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 24 сая ам.доллараар буурсан байна.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 4 дүгээр сард 1,335 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5%-иар, өнгөрсөн сараас 0.7%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,852; 66 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 21%-иар өсч, төмрийн хүдэр 6%-иар буурсан бол өнгөрсөн сараас зэс 0.8%-иар өсч, төмрийн хүдэр 7%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 4 дүгээр сард 79 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 19%-иар, өмнөх сараас 3%-иар тус тус өссөн байна.

Импорт 2018 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 42%-иар буюу 464 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 19 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 8 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүн болон хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт тус бүр 7 нэгж хувийг тайлбарлаж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		307	36%		365	33%		445	28%	58	19%	7%	79	22%	7%
Түргэн эдэлгээтэй	226	172	20%	264	201	18%	283	243	15%	29	17%	3%	42	21%	4%
Хүнс	113	117	14%	101	137	12%	132	169	11%	20	17%	2%	32	23%	3%
Эм, тариа	1	25	3%	1	28	3%	1	32	2%	3	12%	0%	4	15%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	111	30	3%	162	36	3%	150	42	3%	6	21%	1%	6	16%	1%
Удаан эдэлгээтэй	40	135	16%	62	164	15%	54	202	13%	28	21%	3%	38	23%	3%
Гутал, хувцас, цүнх	18	15	2%	20	18	2%	16	22	1%	3	24%	0%	4	23%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	8	27	3%	25	26	2%	17	33	2%	(1)	-5%	0%	7	25%	1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	74	9%	0	102	9%	0	124	8%	28	38%	3%	22	22%	2%
Бусад удаан эдэлгээтэй бараа	14	20	2%	17	18	2%	21	22	1%	(2)	-11%	0%	5	26%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	361	278	32%	322	387	35%	525	605	38%	109	39%	13%	218	56%	19%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	5	160	19%	7	268	24%	7	397	25%	108	67%	12%	130	49%	12%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	29	3%	0	50	5%	0	115	7%	22	75%	3%	65	129%	6%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	5	131	15%	7	217	19%	6	282	18%	86	66%	10%	65	30%	6%
Барилгын материал	158	66	8%	105	74	7%	156	140	9%	8	12%	1%	65	88%	6%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	9	51	6%	13	45	4%	12	68	4%	(7)	-13%	-1%	23	51%	2%
Аж үйлдвэрлэлийн орц	243	163	19%	363	149	13%	438	236	15%	(13)	-8%	-2%	87	58%	8%
Хүнсний орц	109	26	3%	13	6	1%	187	52	3%	(20)	-77%	-2%	46	763%	4%
Химийн бүтээгдэхүүн	38	24	3%	47	27	2%	59	34	2%	3	14%	0%	7	26%	1%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	5	5	1%	11	7	1%	18	8	0%	2	32%	0%	1	17%	0%
Цахилгаан эрчим хүч	0	43	5%	0	43	4%	1	47	3%	1	2%	0%	4	10%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	1	0	0%	0	0	0%	(1)	-77%	0%	(0)	-23%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	208	64	7%	249	66	6%	261	95	6%	1	2%	0%	29	44%	3%
Нефтийн бүтээгдэхүүн	243	114	13%	363	214	19%	438	293	19%	100	88%	12%	79	37%	7%
Дизель түлш	107	44	5%	199	108	10%	256	165	10%	64	144%	7%	57	52%	5%
АИ-92, АИ-95	103	47	5%	114	69	6%	108	73	5%	22	47%	3%	4	6%	0%
А-80 болон бусад	34	23	3%	50	37	3%	74	56	4%	14	62%	2%	19	51%	2%
Бусад	2	1	0%	6	2	0%	71	3	0%	1	136%	0%	1	27%	0%
Нийт дүн		863		1,118			1,582			255	30%		464	42%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	21.3	27%	58.1	73%	79.4	22%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	47.4	22%	170.5	78%	217.8	56%
Аж үйлдвэрлэлийн орц	64.8	74%	22.3	26%	87.0	58%
Нефтийн бүтээгдэхүүн	50.7	64%	28.7	36%	79.4	37%
Дизель түлш	36.7	65%	20.0	35%	56.7	52%
АИ-92, АИ-95	(3.9)		7.7		3.9	6%
А-80 болон бусад	17.9	95%	0.9	5%	18.9	51%
Бусад	2.8		(2.2)		0.6	27%
Нийт дүн	187	40%	277	60%	464	42%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 218 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 87 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний болон нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт тус бүр 79 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 464 сая ам.доллараар өссөн байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 37%-иар өссөн. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 4 дүгээр сард өмнөх сараас 5 хувиар буурсан хэдий ч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар өсч тонн тутамд 643 ам.долларт хүрэв.